



**НИЙСЛЭЛИЙН АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ**

2019 оны 09 сарын 13 өдөр

Дугаар А/73

Улаанбаатар хот

Зочид буудал, дэн буудлын үйл
ажиллагаа эрхлэх зөвшөөрөл олгох,
хүчингүй болгох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.5 дахь заалт, Аялал жуулчлалын тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1.1, Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2011 оны 120 дугаар тогтоолоор батлагдсан “Улаанбаатар хотын нутаг дэвсгэрт аялал жуулчлалын байр сууцны үйл ажиллагаа эрхлэх журам”-ын 5.1, тус газрын дүрмийн 2.5.3-т заасныг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. “Улаанбаатар хотын нутаг дэвсгэрт аялал жуулчлалын байр сууцны үйл ажиллагаа эрхлэх журам” болон “Зочид буудалд тавигдах ерөнхий шаардлага MNS 4588:2008” стандартын шаардлагыг хангасан, тушаалын нэгдүгээр хавсралтад дурдсан аж ахуйн нэгжүүдэд зочид буудлын үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийг нэг жилийн хугацаатай олгосугай.

2. “Улаанбаатар хотын нутаг дэвсгэрт аялал жуулчлалын байр сууцны үйл ажиллагаа эрхлэх журам” болон “Аялал жуулчлал Дэн буудал. Ерөнхий шаардлага MNS 5738:2007” стандартын шаардлагыг хангасан, тушаалын хоёрдугаар хавсралтад дурдсан, аж ахуйн нэгжүүдэд дэн буудлын үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийг нэг жилийн хугацаатай олгосугай.

3. Энэ тушаал гарсантай холбогдуулан Ичмон трэйвел ХХК-ийн “Ичмон” зочид буудлын 18/366, Би ди би си ХХК-ийн “Ану марал” зочид буудлын 18/364, Алтаннаран трейд ХХК-ийн “247” зочид буудлын 18/451, Алтаннаран трейд ХХК-ийн “Эрхэс” зочид буудлын 18/387, Кей си жи ти ХХК-ийн “Алтан тэвш” дэн буудлын 18/212, Алтаннаран трейд ХХК-ийн “Мини” дэн буудлын 18/389 гэрчилгээг хүчингүй болсонд тооцсугай.


4. Зөвшөөрөл авсан байгууллага болон иргэдтэй гэрээ байгуулж үр дүнг тооцон ажиллахыг Захиргааны хэлтэс /Д.Ганболд/-т үүрэг болгосугай.

1150500326

5. Энэхүү тушаалыг Нийслэлийн Мэргэжлийн хяналтын газар, Нийслэлийн Цагдаагийн газар болон дүүргүүдийн Засаг даргын Тамгын газарт хүргүүлэхийг үйлчилгээний байгууллага хариуцсан мэргэжилтэн /Ч.Энх-Отгон/-д үүрэг болгосугай.

6. Гэрчилгээний үнэ болох 5000 /таван мянга/ төгрөгийг тухайн байгууллагаас хураан, Төрийн сан банкны 100200051053 тоот дансанд төвлөрүүлэн, зөвшөөрлийн гэрчилгээний бичилт, олголтод байнгын хяналт тавьж ажиллахыг Ахлах нягтлан бодогч /Б.Батцоож/-д даалгасугай.

ДАРГА



Д. БАТСҮХ

Нийслэлийн Аялал жуулчлалын
газрын даргын 2019 оны 09
сарын 13 өдрийн А/73 дугаар
тушаалын нэгдүгээр хавсралт

5284325 СБТ-8936 1118263502

ЗОЧИД БУУДЛЫН ҮЙЛ АЖИЛЛАГАА ЭРХЛЭХ
ЗӨВШӨӨРӨЛ ОЛГОХ АЖ АХУЙН НЭГЖИЙН
ЖАГСААЛТ


2019 оны 09 дүгээр сарын 13-ний өдөр

Улаанбаатар хот

Д/д	Иргэн, аж ахуйн нэгжийн нэр	Эзэмшигчийн регистрийн дугаар	Оноосон нэр	Байршил
1	Ичмон трэйвел ХХК	6144608	Ичмон	БЗД-ийн, 3-р хороо, 12-р хороолол, Токиогийн гудамж 24/3 тоот
2	Би ди би си ХХК	5381738	Анумарал	БГД-ийн, 9-р хороо, Хасбаатарын гудамж 22 тоот
3	Алтаннаран трейд ХХК	2548542	247	БГД-ийн, 12-р хороо, Хасбаатарын гудамж 36
4	Алтаннаран трейд ХХК	2548542	Эрхэс	БГД-ийн, 12-р хороо, Хасбаатарын гудамж 3а

-ooOoo-

Нийслэлийн Аялал жуулчлалын
газрын даргын 2019 оны 09
сарын 15 өдрийн А/73 дугаар
тушаалын хоёрдугаар хавсралт



**ДЭН БУУДЛЫН ҮЙЛ АЖИЛЛАГАА ЭРХЛЭХ
ЗӨВШӨӨРӨЛ ОЛГОХ АЖ АХУЙН НЭГЖИЙН
ЖАГСААЛТ**

2019 оны 09 дүгээр сарын 13-ний өдөр

Улаанбаатар хот

Д/д	Иргэн, аж ахуйн нэгжийн нэр	Эзэмшигчийн регистрийн дугаар	Оноосон нэр	Байршил
1	Кей си жи ти ХХК	5164303	Алтантэв ш	БГД-ийн, 22-р хороо, Зүүн нарангийн 22-135 тоот
2	Алтаннаран трейд ХХК	2548542	Мини	БГД-ийн, 14-р хороо, 18/1 байр
3	Лундаа ганзага ХХК	2584158	ЛЖ	БГД-ийн, 3-р хороо, Тээвэрчдийн гудамж, АОС 7 тоот

-00000-